Бараа материалын дансны үлдэгдэл 97124.7 мянган төгрөг болж 9647.4 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар бараа материал дээр 11365.3 мянган төгрөгийн материал авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1800815.4 мянган төгрөг болж 19726.9 мянган төгрөгөөр буурсан нь Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2019 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 26 дугаар тогтоолоор 50661.3 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах шийдвэрийн дагуу акталсан, Тайлант онд БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 3586.4 мянган төгрөгийн зөөврийн компьютер, урсгал төсвийн худалдан авалтаар 27548.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1550885.9 мянган төгрөг болж 62064.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 62064.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 898715.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 133291.3 мянган төгрөгөөр буюу 17.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь тусгай зориулалтын шилжүүлэг 747181.5 мянга болж 111897.5 мянган төгрөгөөр өссөн, нэмэлт санхүүжилтийн орлого 51140.8 мянга болж 34226.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 938815.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 78674.3 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 109411.7 мянга, төвлөрүүлэх шилжүүлэг 67512.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 880043.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 880043.9 мянган төгрөгөөр тооцон суралцагчдын тоог 493, ажиллагсдыг 48 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 50,377.7 мянган төгрөгөөр бууруулж анх 837,666.2 мянган төгрөгөөр баталж 2 удаагийн зохицуулалт хийж 841195.2 мянган төгрөгөөр баталсан байна. Суралцагчдын тоог 446, ажиллагсдыг 45 орон баталсан байна. Цалин, НДШ-ын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, эд хогшил худалдан авах зардлыг бууруулан баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 841195.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 747181.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 94013.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 747181.5 мянга, орон нутгийн төсвөөс 94013.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 773667.7 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 66937.1 мянга, орон нутгийн төсөвт 590.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 773667.7 мянган төгрөг буюу 92 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 18881.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 590.4 мянга, хангамж бараа материалын зардлыг 1209.0 мянга, НДШ зардлыг 1444.8 норматив зардлыг 30185.2 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 2.8 мянга, томилт зочны

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

зардлыг 654.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 61.6 мянга, бараа үйлчилгээний зардлыг 239.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Энэ нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хэрэгсэл халдвар хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэх бодис, сургалтын үйл ажиллагааг зогсоосон зэргээс шалтгаалжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 67527.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээний зардлыг 67527.5 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт-2 Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	841,195,200.00	773,667,685.0	67,527,515.0	92.0
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	841,195,200.00	773,667,685.0	67,527,515.0	92.0
АРГА ХЭМЖЭЭ 80109 тогтмол зардал	-	-	-	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,013,700.0	93,423,294.0	590,406.0	99.4
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	-	-	-	-
Нэг удаагийн тэтгэмж	1,438,500.0	1,420,000.0	18,500.0	98.7
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81801 үдийн цай хөтөлбөр	-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг	23,279,000.0	9,039,160.0	14,239,840.0	42.3
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,279,000.0	9,039,160.0	14,239,840.0	42.3
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81806 Дотуур байр	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	114,234,500.0	78,208,051.0	36,026,449.0	68.4
Бараа, үйлчилгээний зардал	114,234,500.0	78,208,051.0	36,026,449.0	68.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,430,500.0	50,551,696.0	6,788,804.0	88.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,167,500.0	7,167,500.0		100.0
Хангамж, бараа материалын зардал	655,200.0	633,200.0	22,000.0	96.6
Норматив зардал	48,228,900.0	19,013,655.0	29,215,245.0	39.4
Эд хогшил худалдан авах	842,400.0	842,000.0	400.0	99.9
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81834 Боловсролын стандарт, сургалтын хэвийн орчин	-	-	-	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	442,876,500.0	432,220,160.6	10,646,339.4	97.6
Бараа, үйлчилгээний зардал	442,876,500.0	432,220,160.6	10,646,339.4	97.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,108,700.0	346,922,712.7	8,185,987.4	97.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,388,600.0	48,252,200.0	136,400.0	99.7
Хангамж, бараа материалын зардал	6,195,400.0	5,550,048.0	645,352.0	63.8
Норматив зардал	2,679,900.0	1,709,900.0	970,000.0	63.8
Эд хогшил худалдан авах	10,111,500.0	10,109,100.0	2400.0	100.0
Томилолт, зочны зардал	1,174,600.0	520,000.0	654,600.0	44.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,147,700.0	1,431,500.0	716,200.0	66.7
Бараа үйлчилгээний бусад зардал	17,794,700.0	17,794,700.0		100.0
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АРГА ХЭМЖЭЭ 81835 сургалтын хэвийн ажиллагаа	-	-	-	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	153,474,200.0	147,603,350.4	5,870,849.6	96.2
Бараа, үйлчилгээний зардал	153,474,200.0	147,603,350.4	5,870,849.6	96.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,391,300.0	130,790,550.4	4,600,749.6	96.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,598,100.0	14,289,700.0	1,308,400.0	91.6
Хангамж, бараа материалын зардал	3,091,500.0	2,549,800.0	541,700.0	82.4
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.0	9,885,000.0	115,800.0	98.9
ХӨТӨЛБӨР 71806 Насан туршийн боловсрол	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 80101 сургалтын хэвийн ажиллагаа	-	-	-	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	11,878,800.0	11,753,668.0	125,132.0	98.9
Бараа, үйлчилгээний зардал	11,878,800.0	11,753,668.0	125,132.0	98.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,356,600.0	10,355,568.0	1,032.0	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,398,100.0	1,398,100.0		100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага х	124,100.0		0	0

Эх сурвалж: Төсвийн хэлбэлзлийн хөтөлбөртэй тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа нь болоогүй мэдээлэл	Байршуулсан аагүй
1	Бүтэн жил	11	11	6	3	2	
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	79	8		9
6	Нийт	27	151	129	11	2	9

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 128 мэдээлэл, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл, тухай бүр мэдээлэх

мэдээллээс 12 дугаар сард 49089,9 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 9,12 дугаар саруудад 121588,0 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээ, нийт 170677,9 мянган төгрөгийн 9 гүйлгээг тус тус мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,"- д заасныг зөрчиж байгаа тул зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 52900.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 3600,0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 3100.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 600.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж, санхүүгийн тайланд 45600.0 мянган төгрөгийн залруулга хийж, албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төлбөрийн актын биелэлтийг Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020.05.29-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Албан шаардлагын биелэлтийг аймгийн Засаг даргын 2020.03.27-ны өдрийн А/206 дугаар захирамж, СХАА-ны 2020.05.18-ны өдрийн 71 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Мөн зөвлөмжийн биелэлтийг Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020.05.18-ны өдрийн 18 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

Хүснэгт 4: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3600.0	2	3600.0	-	-	-
Албан шаардлага	2	3100.0	2	3100.0	-	-	-
Зөвлөмж	2	600.0	2	600.0	-	-	-
Залруулга	1	45600.0	1	45600.0			
Хариуцлага тооцох албан шаардлага	1	0					
Нийт дүн	8	52900.0	8	52900.0	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Тайлант онд аудитаар нийт 21412.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 626.9 төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах албан шаардлага 1, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 20785.1 мянган төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Байхгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 21412.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 626.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийн арилгах албан шаардлага 1 хүргүүлж ажиллаа. Үүнд:

1. Сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан нарт 2020 оны 1,2,4-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 60%-аар бодож 626.9 мянган төгрөгийг илүү олгосон байгаа нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох” журмын 4.4¹ дэх заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1² дэх заалтыг зөрчиж, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан нарт илүү бодож олгосон үр дүнгийн урамшууллыг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Шилэн дансны тухай Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 151 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 128, хугацаа хоцроосон 12, хугацаа болоогүй 2, байршуулаагүй 9 мэдээлэл байна.

¹ Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн багш, туслах багшийн сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүн боловсруулах, цахим сан бүрдүүлэх, уралдаан тэмцээнд хүүхдүүдийг бэлтгэх, жижүүр багшаар ажиллах, эцэг эх, асран хамгаалагчтай харилцах зэрэг ажлыг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн дэвтэр засах, давтлага өгөх, шалгалт, шүүлэг авах, сургалтын арга зүй, технологи, инновацыг хөгжүүлэх, цахим болон интерактив, нээлттэй контент, хэрэглэгдэхүүн боловсруулах, сурагчдын цахим сан бүрдүүлэх, секц дугуйлан хичээллүүлэх, олимпиад, уралдаан тэмцээнд сурагчдыг бэлтгэх, жижүүр багшаар ажиллах, эцэг эх, асран хамгаалагчтай харилцах зэрэг ажлыг тус тус үнэлж албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно

² төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллээс хугацаа хоцроосон 11 мэдээлэл нь тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн 1, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээний 2, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэлийн 1, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн 1, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн 1, тушаал шийдвэртэй холбоотой 1, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 1, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан дүгнэлтийн 1, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1, тус тус хоцорсон байна.

Шилэн дансны тухай хуулийн хүрээнд байршуулаагүй 9 мэдээлэл нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 дугаар сарын 49089,9 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 9,12 дугаар саруудад 121588,0 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээ, нийт 170677,9 мянган төгрөгийн 9 гүйлгээг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийг зөрчиж, санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан мэдээллүүдийг үнэн зөв, иж бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 20785.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг давтан тооцоолоход нийгмийн даатгалын шимтгэлийн 7028.3 мянган төгрөгийн өглөгтэй байхад санхүүгийн тайланд 7238,4 мянган төгрөгөөр буюу 210.1 мянган төгрөгөөр өглөгийг илүү тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

1.3 Өгсөн зөвлөмж: Цаашид Нийгмийн даатгалын байгууллагатай улирал бүр авлага өглөгийн тооцоо нийлж, хяналтыг сайжруулж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Аймгийн БСУГ-ын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар ЕБС-дад "хичээл практик"-ийн зардлыг 10000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүний дагуу "Дэвших болор" ХХК -руу сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885,0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийг тайлант онд хүлээж аваагүй байж, үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэж, тооллогын тайланд биетээр байгаагаар тоолсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, санхүүгийн тайлагналын "Үнэн ба зөв", "Бодитой оршин байх" гэсэн батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

2.3. Өгсөн зөвлөмж: Байгууллагын жилийн эцсийн тооллогоор биетээр байхгүй хөрөнгийг тоолдог зөрчлийг арилгаж, цаашид тооцоог үнэн бодитой, чанартай гүйцэтгэх, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хариуцлагыг дээшлүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Няравын тайланд дотуур байрны хүүхдийн хоол хүнсний зардлаас 5 сард зарцуулсан 2800.9 мянган төгрөгийн анхан шатны баримт, зарцуулалтын тайлан байхгүй, мөн бараа материалын тайлангийн бусад хангамжийн материал гэсэн дансанд үдийн цайны хүнсний материалын бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын 4.21 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

3.3. Өгсөн зөвлөмж: Цаашид бараа материалыг орлого авах, зарлага гаргахдаа анхан шатны баримтын бүрдлийг шалгаж, түүнд үндэслэж нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үдийн цай хөтөлбөрийн бараа материалын хүнсний тайланг зөв ангилалд бүртгэх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Балансын данстай холбоотой асуудал

4.1.Илрүүлэлт: Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад бүх гүйлгээг анхан шатны баримтаас хөөн шалгахад ө- баримтгүй 7137.1 төгрөгийн 3 гүйлгээ, анхан шатны баримтгүй 752.0 төгрөгийн 2 гүйлгээ байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, “Татварын ерөнхий хуулийн 28.5 “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2.Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

4.3. Өгсөн зөвлөмж: Цаашид аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс худалдан авалт хийхдээ дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлүүлж авах болон E-баримт.mn сайтаар өөрийн байгууллагын нэр регистрээр шивүүлж, худалдан авалтад хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5. Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

5.1.Илрүүлэлт: Тайлант хугацааны нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээг тулган шалгахад аймгийн БСУГ-аас тус байгууллагын үйлчлэгч Ц.Нарантуяад 13073.9 мянган төгрөгийн өндөр насны тэтгэмжийг олгохоор төсөв батлагдсан ч уг иргэн 1967 онд төрсөн 3 хүүхэдтэй тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох эрх үүсээгүйгээс тэтгэмжийг олгоогүй Төрийн санд буцаан төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Даатгуулагч нь нийтдээ 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-оос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”,6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2.Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

5.3. Өгсөн зөвлөмж: Цаашид тухайн оны төсвийн төслийг боловсруулахдаа ажилтнуудын өндөр насны тэтгэмжийг хууль журмыг мөрдлөг болгон үнэн зөв, үндэслэлтэй төлөвлөж байх.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ
ОГНОО: 2021.02.18

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.18

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.18



Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/99/СТА-ТШЗ		
2020					
Шалгагдсан байгууллагын нэр:		Галуут сумын Ерөнхий боловсролын сургууль			Мянган төгрөг
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-д заасан 12 дугаар сарын 49089.9 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 9,12 дугаар саруудад 121588.0 мянган төгрөгийн 8 гүйлгээ, нийт 170677.9 мянган төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй байна.	0	Албан шаардлага	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Дагвадорж, М.Мягмарсүрэн
2	Сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан нарт 1,2,4-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 60%-аар бодож 626,9 мянган төгрөгийг илүү олгосон байна.	626.9	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Дагвадорж, М.Мягмарсүрэн
3	Цалингийн тооцооллыг давтан тооцоолоход нийгмийн даатгалын үлдэгдэл 7028.3 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд 7238,4 мянган төгрөгөөр өглөг үүсгэж 210.1 мянган төгрөгөөр илүү тусгасан байна.	210.1	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Дагвадорж, М.Мягмарсүрэн
4	2020 оны 12 дугаар сард "Дэвших болох" ХХК руу сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885,0 мянган төгрөгийг шилжүүлсэн ч тайлант онд тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгах байтал үндсэн хөрөнгөд орлого авсан байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тухайн мөнгөөр худалдан авалтыг хийхээр мөнгийг шилжүүлсэн байна.	9885.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Дагвадорж, М.Мягмарсүрэн
5	Няравын тайланд дотуур байрны хүүхдийн хоол хүнсний зардлаас 5 сард зарцуулсан 2800.9 мянган төгрөгийн анхан шатны баримт, зарцуулалтын тайлан байхгүй, мөн бараа материалын тайлангийн бусад хангамжийн материалын дансанд үдийн цайны хүнсний материалын бүртгэсэн байна.	2800.9	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Дагвадорж, М.Мягмарсүрэн



Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад бүх гүйлгээг анхан шатны баримтаас хөөн шалгахад ө баримтгүй 7137.1 төгрөгийн 3 гүйлгээ, анхан шатны баримтгүй 752.0 төгрөгийн 2 гүйлгээ байна.	7889.1	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Дагвадорж, М.Мягмарсүрэн
7	Тайлант хугацааны нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээг тулган шалгахад аймгийн БСУГ-аас тус байгууллагын үйлчлэгч Ц.Нарантуяад 13073.9 мянган төгрөгийн өндөр насны тэтгэмжийг олгохоор төсөв батлагдсан ч уг иргэн 1967 онд төрсөн 3 хүүхэдтэй тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолох эрх үүсээгүйгээс тэтгэмжийг олгоогүй Төрийн санд буцаан төвлөрүүлсэн байна.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Дагвадорж, М.Мягмарсүрэн
ДҮН		21412.0			